



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.mn](https://www.facebook.com/Rtcc.mn)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 10-р сарын дугаар



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна

Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг тогтсон хугацаанд үнэн зөв мэдээ мэдээллээр хангаж “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК-ын цахим хаягт хандах эрхээр орж ачилт буулгалтын мэдээ, галт тэрэг, вагон солилцооны мэдээ, ачааны паркийн мэдээ, нүүрс хангарт, нөөцлөлтийн хоногийн болон сарын мэдээг авч мэдээллийг боловсруулж салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж ажиллалаа.




Статистик мэдээллийн нэгдсэн санд бүрдсэн 10-р сарын статистик мэдээг нэгтгэн боловсруулж урсгал диаграмм, график гарган байгууллагын цахим хуудаст байршуулсан.

“Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ыг шинэчлэн боловсруулж үндэсний статистикийн хороогоор батлуулах хуралд оролцон хурлын маягт 8, маягт 10, Т3-4 маягтыг дахин боловсруулж маятуудын өгөгдөл дээрх тодорхойлолтуудыг бөглөх зааврын хамт бэлтгэн үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.



2018 оны 10 дугаар сард өссөн дүнгээр зорчигч тээвэрлэлт 2177.1 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 3.6%-аар буурсан, ачаа тээвэрлэлт нь 21109.9 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.


ИНФОГРАФИК



СТАТИСТИК


/2018 оны 10 дугаар сарын байдааар/

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2018 оны аравдугаар сард 215.7 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3.6%-аар буурч, ачаа тээвэрлэлт нь энэ сарын байдааар 2388.9 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үесц 7.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Ачилт- ачааны төрлөөр /2018 оны 10 дугаар сард/



Дамжин өнгөрсөн ачаа /тонноор/



Дамжин өнгөрсөн ачаа 2018 оны аравдугаар сард 267273.4 тн ачсан нь өнгөрсөн оны мөн үесц 9368.4 тн буюу 3.6 хувират ёссөн үзүүлэлттэй байна.

2018 оны аравдугаар сард нүүрс, жонш, барилгын материал, нефтийн бүтээгдэхүүн, төмрийн хүдэр ёссөн үзүүлэлттэй байна. Нийт 1919.9 мян.тн ачаа ачсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.2% ёссөн байна.

Нүүрс	46%
Төмрийн хүдэр	28%
Барилгын материал	10%
Бусад материал	10%
Жонш	4%
Нефтийн бүтээгдэхүүн	2%

Мэдээ, мэдээлэл




Суурь бүтцийн 2018 оны 10-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайлан


2018 оны 10-р сард нийт 160 тасалдал, 168,7 галт тэрэг цагийн барилт үүсч, 26,6 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:

Тасалдлын хэмжээ, тоо



Тасалдлын хэмжээ, г/т цаг




Тасалдлаас үүссэн хохирол, сая төг



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 12 нэгж буюу 6,9%-иар, галт тэрэг цаг 49,2 цаг буюу 13,6%-иар, хохирлын хэмжээ 6,82 сая төгрөг буюу 20,4%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:

Тасалдлын тоо





Хөдлөх бүрэлдэхүүний тусlamжтай суурь бүтэц дэх хөдөлгөөнийг хянах төхөөрөмжийн технологийн 4 шийдлийг боловсрууллаа. Үүнд:

1. Сансырын хиймэл дагуул ашиглан галт тэрэгний байршил илрүүлэх хяналтын систем,
2. Оптик тэмдэгт танигч камерын систем,
3. Бар код уншигч вагон дугаар танигч,
4. GPS болон GSM сүлжээ ашиглан галт тэрэгний байршил илрүүлэгч чипний систем багтаж байна. Уг шийдлүүдийн үнийн санал, суурилуулалтын талаар гүнзгийрүүлэн судалж байна.



Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдлээ. Гэрээний хэрэгжилт 2018.09.20-ны байдлаар 81.3, 2018.10.30-ны байдлаар 85.2 хувийн хэрэгжилттэй байгаа бол, жилийн эцсийн өссөн дүнгээр /2018.12.01/ хувиар 93.6, оноогоор 91.4 болох урьдчилсан прогноз гаргалаа.



Үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр хийж байгаа ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг албан бичгээр яамны ХШУДАГ-т хүргэж танилцуулсан.



Мөн төвийн үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ил 14 үзүүлэлтийн хэрэгжилт 2018.10.16-ны өдрийн байдлаар 80,77 хувийн биелэлттэй байна.

“Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих” ажлын хүрээнд:

- “УБТЗ” ХНН-ийн 2018 оны 9-р сарын 27-аас 10-р сарын 31 хүртэлх тасалдлын мэдээг нэгтгэн тайлан гаргаж ажиллаж байна.

“Монгол Улсын хилээр нэвтрэч буй хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох ажлыг зохион байгуулах, бүртгэх, эрх бүхий хуулийн этгээдийг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:

Мэдээ, мэдээлэл

- “МАК” ХХК-ийн албан хүсэлтийг судлан 258 тоот албан бичгээр хариу хүргүүлж тус компанийн 30 хоппер вагоны дугаарыг баталгаажууллаа.
- “ТЗЗТИ” ХХК -д 261 тоот албан бичгээр 14 ачааны хагас вагонд дугаар олгосон.
- “Мөнгөн хөдөлгүүр” ХХК-ны сэлгээний 1 илчилт тэргийг “МАК-Цемент” ХХК-ны нэр дээр бүртгэл хийж, дугаар олгосон.
- “ТЗЗТИ” ХХК-ийн ирүүлсэн албан бичгийг судлан хянаж 10 вагонд дугаар олгож программ хангамжид бүртгэлээ.

“Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009 стандартыг орчуулан боловсруулах” ажлын хүрээнд:

- “Dorniinerdem Translationc” ХХК- тай хамтран тус стандартыг эцсийн байдлаар хяналт хийн ажиллаж байна.

“Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлах” ажлын хүрээнд:

- “Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журам”-ын шинэчлэн найруулсан төслийг боловсруулсан.

“Төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн төслүүдтэй танилцах, санал хүргүүлэх” ажлын хүрээнд:

- Төмөр замын аюултай бүс, төмөр замын зурvas газар, аюулгүйн бүсэд төмөр замын болон бусад объект байрлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нэвтрэх журам болон Суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загварын төсөлд оруулах санал боловсруулсан.



Мэдээллийн цаг, сургалт арга хэмжээ:

Хан-Уул дүүргийн “Албан бус - Насан туршийн боловсролын төв”-өөс зохион байгуулсан “Монгол хэлний шинэчилсэн найруулга болон зөв бичих дүрэм”, “Зөв зохистой хооллолт”-ын тухай сургалт, 2018.10.09-ний өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Ажил олгогч, удирдах ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” сургалт, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа”, “Төмөр замын ерөнхий зохион байгуулалт” сэдэвт сургалтуудад тус тус хамрагдсан.

Салбарын үйлдвэрчний эвлэлийн холбооноос зохион байгуулсан нийт бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг чийрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан спортын арга хэмжээ болох “Төмөр замын Зангилаа”-ны аварга шалгааруулах тэмцээнд “УБТЗ” ХНН-ийн Удирдах





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
З-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

